

STUDIA FOLCLORICA
FOLKLORE STUDIES<https://doi.org/10.5564/sf.v45i1.4819>

Tom. XLV

2024

fasc. 10

“Богд чингис” хэмээх цоорын дууны
шүлэгт хийсэн ажиглалтЗидмаагийн САРАНГЭРЭЛ*
МУБИС, Боловсрол судлалын сургууль

Received: Jun 20, 2024

Revised: Jul 123, 2024

Accepted: Aug, 25, 2024

Хураангуй: Монгол уртын дууны судалгаанд зан үйлийн учир зориулалтыг харгалзах зарчмыг баримтлан монгол цоор уртын дуунаас “Богд Чингис” дууг сонгон авч цуглуулсан хувилбаруудад үгийн болон шүлэг зүйн задлан шинжилгээ хийжээ. Цоор уртын дуу нь монгол уртын дууны нэгэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд олуул дуулахдаа дуучдын нэг хэсэг нь хоолойн өвөрмөц дуугаралт гарган дэвсгэр өнгө болгож, энэ өнгөн дээр нэг нь гоцлон дуулна. Эцэст нь бүгдээр түрэн хөгжөөж дуулна. Судлаачид цоор дууг ордны ёслолд дуулдаг хүндэтгэлийн дуулах хэлбэр гэж үздэг. Чингэхдээ монгол уртын дууны шүлгийн судалгааны тоймыг дурдаж, тэдгээрийн онолын чиг баримжааг авсан байна. Аргазүйн хувьд, тус цоор дууны шүлгийн бичвэрт үг, текстийн тооцоолол хийдэг программыг ашиглан бүтэц зүйн судалгаа хийхийг зорьжээ. Судалгааны үр дүнд,

1. “Богд Чингис” цоор дуу нь аялгууны хувьд Авга, Авга нарын үндсэн хэлбэрээс эх авч хөрш зэргэлдээ Ар хорчин, Зуу-Уд, Үзэмчин аялгуу гэсэн монгол угсаатны бүлгүүдэд хувилбарлан орсон гэж үзжээ.
2. Тус дууны шүлгийн 7 гол хувилбарыг сонгон зэрэгцүүлж, холбогдох домогтой уялдуулан үзэж тус дуу нь найрын дууны агуулга хэлбэртэй боловч Чингис хааны үеийн архи сархдыг хэрэгдэх ёстой холбоотой, хурим найрыг нээдэг засал домын чанартай дуу байсан байж болзошгүй гэдэг таамаглал дэвшүүлж дууны зарим үг, мөрийг баталгаа болгож

Түлхүүр үг: уртын дуу, цоорын дуу, Чингис хааны тухай дуу, шүлэглэл, хувилбар

Analysis on the lyric of Mongolian
tsoor-long song “Bogd Chinggis”SARANGEREL zidmaa
Mongolian State University of Education,
School of Educational Studies

Abstract: The author selected the song ‘Bogd Chinggis’ from Mongolian extended songs tsoor and analyzed the collected version of these songs for their lyrical and poetic structure, guided by the principle of taking into account the ritual purpose. The Mongolian tsoor song is an integral part of the Mongolian extended song. This song is performed by several singers, some of them create a unique khuumii sound as a background for the melody, and one of them sings solo on this background. Finally, everyone sings ‘turleg.’ The researchers believe that the long tsur song is performed during palace ceremonies. For the purpose of methodology, the author conducted a structural study using a computer program that counts words and lyrics in the lyrics of the song. The results of the study showed that,

1. The extended tsoor song ‘Bogd Chinggis’ is believed to have originated from the main form of Avgi, Avgi khoshun in Inner Mongolia and was adapted in neighboring Mongolian ethnic groups as the extended song of Arhorchin, Zuu-Ud and Udzemchin.
- 2 The author selected 7 main versions of the text of this song, compared them with relevant legends and hypothesized that the song could have been a ceremonial song that opened a wedding feast associated with alcohol consumption in the Chinggis Khan era. The author confirmed some words and lines of the song with this hypothesis.

Key words: Bogd Chinggis, tsoor song, text, Arhorchin, Zuu-Ud and Udzemchin.

Удиртгал хэсэг

Монгол ардын дууны яруу найргийн судалгаа харьцангуй сайн хийгдсэн ч уртын дууны шүлгийн талаар илүү нарийн түвшний судалгаа шаардлагатай хэвээрээ байна. Тухайлбал, уртын дууны шүлгийн ерөнхий хэв шинж ямар болох, түүний дотор цоорын уртын дууны шүлгийг тусгайлан тодорхойлоогүй явж иржээ. Иймд бид цоорын дууны дотроос эрхэм хүндэтгэлт “Богд Чингис” дууг сонгон авч шүлэг зүйн талаар задлан шинжилгээ хийж, энэ явцад дууны зан үйлийн зориулалтыг тодорхойлохыг зорилгоо болгов.

Судалгааны тойм

Бид энэхүү илтгэлдээ монгол уртын дуу, цоорын дуу болон зан үйлийн дуу, монгол шүлэг зүй зэрэг хэд хэдэн судалгааны чиглэлийн бүтээлүүдийг ашигласан бөгөөд гол асуудалд хамаарах судалгааны тоймыг энд дурдлаа.

* © З.Сарангэрэл
Email: 1305691228@qq.com

Монгол аман яруу найраг, зан үйлийн уялдаа холбооны талаар БНХАУ-ын нэрт эрдэмтэн Мандах, академич Цогжин (туулийн яруу найраг) тэргүүтэй судлаачид болон Монгол Улсын эрдэмтэн академич Х.Сампилдэндэв “Монгол ардын зан үйлийн аман зохиол” (1987), “Монгол зан үйл, аман зохиолын харьцуулсан судалгаа” (2004), “Монгол хуримын яруу найргийн төрөл зүйл” (Хоёр дахь хэвлэл. УБ., 2015) мөн доктор Г.Гантогтох “Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал” (2007) зэрэг тусгайлсан бүтээлүүд хэвлэгджээ.

Цоорын дууны яруу найргийн хувьд дараах бүтээлүүдийг судалгааны тоймд хамааруулж байна. Үүнд, Монгол улсын судлаач Б.Содном, академич Б.Ринчен, Д.Цэрэнсодном, Д.Цэнд, Д.Галбаяр, Лагсагмаа (ӨМӨЗО) зэрэг эрдэмтэд задгай шүлэг буюу чөлөөт хэмжээт шүлгийн тухай судлан бичсэн бөгөөд тэдний онол, чиг баримжаа бидний энэхүү судалгааны нэгэн үндэслэл болно. Учир нь бид цоорын дууны яруу найргийг монголчуудын уламжлалт хэллэгээр цагаан шүлэг буюу чөлөөт хэмжээт шүлэгт хамаарна гэж үзэж байгаа юм.

Цоорын дууны судалгааны бүтээлүүдээс “Богд Чингис” дуунд хамаарах судалгааны тоймыг товч дурдвал, 1930 онд дуучин Дамдин энэхүү дууг анх бичлэгт шингэн үлдээсэн (1988 онд Япон улсаас илрүүлсэн) бол 1998 онд Ишгомбо, Баянцагаан, Лхажав нарын дуулсан хувилбар гэх мэтээр цааш үргэлжилж байна.


Ном хэвлэлийн хувьд, С.Баянжаргалын “Уртын дуу, цоордуу, хөөмий” (2009), Дорж, Улаангэрэл нарын “Тэнгэр газрын хүн аялгуу” (2011), Н.Лхамсүрэнгийн “Зүрхэнд уянгалах уртын дуу” (2013), Т.Санжаагийн “Үзэмчин ардын дуу” (2012), Н.Бөххад, Отгонбаатар нарын эмхэтгэл “Үзэмчин ардын домогт дуу” зэрэг бүтээлийг дурдаж болно.

Судалгааны арга

Судлаачдын философи, утга зохиол, хэл шинжлэл, соёл судлалын үзэл баримтлалд тулгуурлан сэдвийг ойлгоход шаардлагатай монгол ардын дууны бичвэрийн судалгааны арга, үг-утгыг илэрхийлэх соёл-семиотик арга; зан үйл шүтлэг, шүлэг зүйн онолын холбогдох аргуудыг сонгон ашиглав.

Үндсэн хэсэг

Монгол уртын дуу олон зууны турш бүрэлдэн төлөвшихдөө өөртөө олон янз хэлбэрийг шингээн нутаг нутгийн хэв шинжийг олж төгөлдөржсөөр иржээ. Бидний мэдэхээр, судлаачид уртын дууг хэв шинжийн хувьд ангилан үзэхдээ юуны өмнө аялгуу, дуулах хэв маяг болоод агуулга, хэлбэр, зохиомж тэрчлэн зан үйл, нутаг дэвсгэрт тархсан дэлгэрсэн байдал, хөгжлийн түүхэн тойм, үг шүлэг зэрэг олон талаас судалснаар сая айзам, бэсрэг, шастир гэх мэтчилэн том төрлүүдэд хуваан үзэх болсон билээ. Тэдгээр том төрлийн нэг нь ӨМӨЗО-ны Авга, Авганар хошуугаар төвлөрсөн цоорын дуу бөгөөд бид, монгол уртын дууны айд цоорын дуу өөрийн гэсэн баттай байр суурийг эзлэх ёстой гэж үзэж бүдүүвчлэн үзүүлэв.



Бүдүүвч 1. Цоорын дууны байр суурь

Уртын дууг ийнхүү төр-иргэн, иргэний аж байдал, шашин-гүн бясалгалын гэсэн гурван төвшнөөр ангилсан нь судалгаанд олон жилийн турш орхигдож ирсэн *нэгд*, зан үйлийн учир зориулалт, *хоёрт*, үг хэллэгээр дамжин илрэх агуулга, утга санааг харгалзан үзэх гэсэн хандлага юм.

1. Уртын дууны ангилалд зан үйлийн учир зориулалтыг харгалзан үзэх нь ардын дууны доторх хэв шинжээрээ ижилссэн бүлгүүдийг тогтоох, дууны ангиллыг хийхэд чухал шалгуур болдог тул ардын дуу ба зан үйлийн уялдаа холбооны талаар олон тооны ном бүтээл хэвлэгджээ. Тэдгээр судалгааны баримжаагаар ардын дууг зан үйлийн шинжээр нь хоёр үндсэн чиглэлд хувааж байна (Круглов, 1989:7-8). Үүнд,

а) Зан үйлийн үүрэг гүйцэтгэдэг дуунууд. Эдгээр дуунд ид шидийн зориулалт илт давамгайл байх бөгөөд жишээ нь, тайлга тахилга хийх үед тусгай дуу дуулж засал хийх, дом шившлэгийн чанартай, гашуудал тайлах үед дуулдаг уртын дуу гэх мэт.

б) Зан үйлийн ёслолын үед дуулдаг, тухайн ёслолд нэмэлт үүрэг гүйцэтгэх дуунууд. Өөрөөр хэлбэл, ямар нэг зан үйлийн ёслолд оролцогчид энэ үйл явдалд хандаж буй хандлагаа илэрхийлж дуулдаг дуунууд юм. Жишээ нь, хуримын үед ээж нь гэрлэж буй охиндоо хандаж сургаалын агуулгатай дуу дуулах гэх мэт.

Дээрх шалгуураар, монгол уртын дуу шууд өөрөө зан үйл гүйцэтгэж байна уу, эсвэл тухайн ёслолыг чимж, нэмэн тодчилж байна уу гэдгийг мэдэхэд цоорын дуу, түүний агуулга, утга санааг илэрхийлж байгаа шүлгийг задлан авч үзэх нь чухал ач холбогдолтой юм.

2. Аман зохиолын хэлний судалгаа хүчтэй байгаа нь уртын дууны үг, шүлгийн судалгааны суурийг илүү найдвар, илүү бодит болгох болжээ.

“Богд Чингис” дууны олон тооны хувилбарыг бид цуглуулан ая аялгуу, бичвэр зүйн үүднээс ажиглалт хийхэд уг дууны Авга, Авга нарын үндсэн аялгуунаас улбаалсан Ар хорчин, Зуу-Уд, Үзэмчин аялгуу гэсэн угсаатны зүйн шинжтэй дараах бүлэгт хуваагдаж байна. Үүнд:



“Богд Чингис” уртын дууны бичвэрүүдийг дараах байдлаар бүлэглэн үзлээ.

Д/д	Товчилсон тэмдэглэл	Хувилбар	Эх сурвалж		Хамаарах бүлэг
1	[А 84]	А	С.Баянжаргал “Уртын дуу, цоор дуу, хөөмий” (Гонкон тян ма хэвлэлийн компани. 2009)	84 дэх тал	
2	[Б 124]	Б		124 дэх тал	Зуу-Уд
3	[В 264]	В	Дорж., Улаангэрэл “Тэнгэр газрын хүн аялгуу” (ӨМАХХ., 2011)	264 дэх тал	
4	[Г 265]	Г		265 дахь тал	
5	[Д 266]	Д		266 дахь тал	
6	[Е 266]	Е		266 дахь тал	
7	[Ж 269]	Ж		269 дахь тал	

“Богд Чингис” цоорын дууны дээрх хувилбаруудыг ажиглахад [А 84], [В 264] хоёр ижил бөгөөд уртын дуу судлаач С.Баянжаргал гуайн хувилбар анхны хэвлэл гэж харагдаж байна. Хэмжээний хувьд [Г 265] [Д 266] хувилбар богино, харин [Ж 269] хувилбар 24 мөртэй төдийгүй [Ж 269], [Е 266] хувилбар утга санааны хувьд бусад хувилбарт байхгүй нэмэлтүүдийг агуулжээ. Тухайлбал, Е 266] хувилбар хуримлан буй хос залууст эцэг эх, ах дүү төрөл төрөгсдийн зүгээс дуулдаг дуу мэт, “Булбарайхан хоёр үрийн чинь, хайртай хоёр үрийн чинь, амраг үрсийн чинь найр байна, найрлаад сууя” гэссэн мөрүүдтэй болжээ. Мөн Ар зуу,Өвөр зууд эргэж мөргөөд гарья гэсэн нэмэлт мөрүүд байгаа нь ч тус дуунд нэлээд баяжилт орсныг харуулж байна. Тэгвэл [Ж 269] хувилбарт,

Найман хүүтэй шатраа
Найрын дуунд сөгнөж (?)
Насны буянтан тандаа
Найрын хөгжмөө өргөө!

Үзмийн амтат сархдаа
Үзэмжит найртаа сөгнөөд
Өршөөлт дээд тантайгаа
Өнөдийн баяраар найрлая!
Ертөнц дэлхийг гийгүүлсэн
Эхэс дээдэс тантайгаа
Есөн хүслийн цэнгэлээр
Журамтай баяраар найрлая!

гэх мэт харьцангуй олон зүйлийг багтаах гэсэн эрмэлзэл бүхий бадгууд нэмэгджээ.

Бид олон хувилбаруудаас, [А 84], [В 264]-ыг гол болгон задлан шинжилж үзлээ. Энэхүү хувилбар нь “Зээ” гэсэн эхлэлтэй, тус бүр 4 мөр бүхий 3 түрлэгтэй энэ хувилбарын бичвэрт үгийн статистик тооцоо хийж үзвэл, кирилл үсгийн тэмдэгтээр нийт 316 тэмдэгт, 44 үг байгаагаас идэвхтэй үг-21. Үгийн давталт нийт бичвэрийн 20% орчмыг эзэлж байна.

Бичвэрийн гол тулгуур буюу цөм үгс гэвэл **журам (зан журам), Монголын, Чингис, зохиосон, олноороо** гэсэн үгс болно. Эдгээр үгийн давталтын тоо 3-2 буюу бичвэрийн 6.2%-ийг эзэлж байна.

[А 84], [В 264] бичвэрийн нийт үгийн 52% нь (давтагдалгүй) тэмдэг нэр, жинхэнэ нэр 24%, үйл үг 14% байгаагийн зэрэгцээ оноосон нэр 10%-ийг эзэлж байна. Дууны бичвэрт нэр үг биш харин тэмдэг нэр, өөрөөр хэлбэл жинхэнэ нэрийг тодотгох үгс голлох байртай байгаа нь эрхгүй сонирхол татна. Үйл үг цөөн байгаа нь энэ дууны шүлгийн эртний чанар гэж хэлэх үндэслэл гэж үзэж болно.

“Богд Чингис” дууны [А 84], [В 264] хувилбарт шүлгийн үе, хэмнэл, холбоцыг тооцоолохдоо шүлгийн үеийг монгол бичгийн бичлэгийн хэлбэрээр авч үзэв. Нарийвчилбал,

- 1-р бадгийн үе 8, 9, 9, 11
- 2-р бадгийн үе 8, 9, 8, 11
- 3-р бадгийн үе 8, 9, 8, 9 байгаа нь нэн жигд буюу дунджаар 8

үетэй байгаа нь монгол шүлгийн мөрийн дундажтай таарч байна.

Тус хувилбар Бо- (Бу-, Бү-), Ха-, Э- зэрэг авиагаар толгой холбож “зохиосон”, “сөгнөө” хэмээх үйл үгс, “журам аа” зэрэг нэр үгээр сүүл холбожээ. Мөн бадгуудыг “сөгнөө” гэсэн үгээр товчилж төгсгөсөн нь дууг 1-р биеэс бусдад хандаж хамт олныг уриалсан агуулгатай утгын өргөлт үүсгэсэн байна. Энэ нь судлаачийн үзсэнчлэн задгай шүлэг нь “дүрслэгдэхүүнийхээ үйл явдлын өрнөлийг уран сайхны аргаар зааглах үүднээс шүлгийн төгсгөлд өргөлт өгөгдөж сүүл холбоц үүсдэг байна” (Галбаяр, 2017:2) гэсэнтэй таарах ажээ.

Үе, үгийн тоо тэгш харьцангуй хэмтэй, “Зээ” гэсэн эхлэл, төгсгөлтэй холбогдож аялгууг тэнцүүлж байгаа учраас “Богд Чингис” дуу нь цоорын дуу дотроо шилдэг зохиомжтой, аялгуу сайтай, ойр зэргэлдээ угсаатны бүлгүүдэд олон хувилбар үүсгэн тархсан бололтой.

Дууны шүлгийн зохиомж ерөнхийдөө тэгш хэмтэй байгааг дараах байдлаас харж болно.

Богд	Чингисийн зохиосон	Бүгд	Монголын	зан журам
Хаан		Хамаг		
Эзэн		Их		

Бутантай	сайхан сархдаа	Бүгд	Олноороо (бүгдээрээ)	өргөн сөгнөө
Хадаг хорзтой		Хамаг		
Эрчимтэй		Эн		

Доктор Л.Галбаяр “Шүлгийн мөр хоорондын үгс хоорондоо нарийн холбоо хамааралтай байх нь ойлгомжтой зүйл хэдий ч цаанаа нүүдэлчдийн бүх ажил хоорондоо холбоотой нэгээс нөгөө нь урган ундарч байх зүй тогтлоос үүдэлтэй хэрэг. Шүлгийн нэгдүгээр мөрөөс хоёрдугаар мөр урган гарна” гэсэн байдагчлан нэгдүгээр бадгаас хоёрдугаар, гуравдугаар бадаг үүдэн бүтжээ.

Мөн Чингис хаан, Монгол, сархад, олноор хэмээх үгсийг олон янзаар тодотгосон нь ур чадвар, үгийн баялгийг харуулна. Чингэхдээ тус дуунд үйл үг бус тэмдэг нэр олон байна. Гэхдээ бичвэрт тулгуур (түлхүүр) үг болж чадахгүй бөгөөд шүлгийн гол агуулга нь Чингис хаан, Монгол, зан журам гэсэн 3 утгын тулгуур үүсгэжээ.

Шүлгийн задлан шинжилгээний эцэст өгүүлэхэд тус шүлэг нь ихэвчлэн тодорхой үгээр холбогддог онцлог бүхий сүүл холбоц голлосон, уран дүрслэлийн аргыг чөлөөтэй хэрэглэсэн, гол нь сонсголонг чанарт тулгуурласан задгай шүлэг болно.

“Богд Чингис” хэмээх энэ дууны шүлгийн агуулгыг ойлгохын тулд түүний домгийг товчлон өгүүлбэл, Нэгэн цагт Чингис хаан Өэлүн эхдээ хандан манай дээдэс гурван үе архины шалтгаанаас эндэл болсон тул архийг чанга цаазалсугай гэсэн зарлиг буулгаж улсын хэмжээнд найр наадам, билэг ерөөл, дуу шүлгээр хомсхон болж ард олны сэтгэл сэргээх цэнгэл ба тэнгэр лусын эзэнд өргөх дээж сацал тасран эс баяссанаар гамшиг олон болсон нэгэн учир үүджээ. Чингис хаан нэгэн өдөр өөрийн биеэр хойд зүгт морилж хол газар нэгэн өндөр уулан дээрээс харваас ард нь нэгэн бүлэг айлууд үзэгдэн тэр газарт төрөл бүрийн мал сүрэг бэлчээрлэн хур бороо нь элбэгээс өвс бэлчээр дэлгэрэн шим хүч нь элбэг байгааг үзээд Богд эзэн баяртай морилон хүрч тэр айлд буухад нэгэн өндөр насалсан өвгөн гарч Богд эзнийг угтан залж, гэрт буулгаж, зочныг гэрийн эзний ёсоор уулзан амар мэнд асуулцан, цай барин идээ дэвшүүлэн, гэрийн эзэн өвгөн бас монгол хөрөнгөнөөс нэрсэн архийг хас аяганд дүүргэн хийж, Богд Чингис хаанд өргөн барьж настай өвгөн ийнхүү дуулав:

“Богд Чингисийн зохиосон
Бүх монголын жам ёс
Бурмын амтат сархдаа сөгнөн

Бүгд хамтдаа найрлая
Хаан Чингисийн зохиосон
Хамаг монголын жам ёс
Хатан хурц сархдаа сөгнөн
Хамт олноороо найрлая гэв” (Дорж, 2011: 204-205).

Түүнд Богд Чингис хаан архийг тосож амсан дуу өргөж архи дахин сэргээн өвгөнд хариу сархад бариад ийнхүү асууна: “Манай улсын хэмжээнд ган болж байтал эрхэм танай энд яагаад хур бороо орж, өвс бэлчээр дэлгэрээд мал сүрэг таргалсан бэ?” гэсэнд өвгөн: “Хүндэт зочин танаас юу нуух вэ? Дээд эзний зарлигаар архи цаазалснаар найр наадам ховор болж сайн бэлэгт дуу шүлэг, хөгжим буйгаас болж бэлэг ерөөл дутагдан тэнгэр дэлхийн эзэд дээд сацал тасарч сахиус нь эс баясаад ган зуд элбэг бороо хур тэгшгүй болжээ. Манай бага газар хэсэг бүлэг нутгийн ард бид нэр хөрөнгөө нэрж төрийн ундаа сархад цэгээ гаргаж, тэнгэр дэлхийн эздэд дээж сацал дэвшүүлэн, бэлэг ерөөл тавин сайн бэлэгт дуу шүлэг дуулан найр наадам хийснээс шүтээн сахиусан хур борооны цагаар орж, гамшгийн үргэлжлэл тасран орон нутаг шим лугаа төгөлдөр болж, мал сүрэг дэлгэрэн олон бүхэн жарган сууж байна. Энэ учрыг цаазын дээгүүр цэнгэлийн доогуур хийсэн болой, үүнээ санаандгүй эрхэм хүнд мэдэгдэх бид” гэв. Үүнээс Богд Чингис хаан ордондоо хүрч Өүлэн эхдээ мэдүүлж зөвшөөрүүлсэн архины цээрлэлийг тайлан ийнхүү зарлиг гаргажээ. “Архи хэмээгчийг багахан ууваас жаргал, Балартал согтвоос мунхаг, Билэг төдий ууваас рашаан, Биеэ согттол ууваас хор” түүнчлэн хэмжээтэй цааз тогтоон сархад сөгнөн билэг ерөөл хэлэх найр наадам дэлгэрүүлснээр олон нийтээрээ ган зудын үргэлжлэл тасарч амар цэнгэн жаргаж суужээ” (Бөххад, 2005:10,13) гэсэн домог бий.

Энэхүү домгийн өөр нэгэн хувилбар Монгол Улсад хэвлэгдсэн “Монгол домгийн цоморлиг” (Эмхэтгэсэн Х.Сампилдэндэв) бөгөөд “Богд Чингис” төдийгүй “Эртний сайхан” дуутай холбогддог (Сампилдэндэв, 2005:115-119). Архи сөгнөх, барих, архийг хүндэтгэж уух, монгол нутагт гэртээ бүрхээрээр архи нэрэх болсон зэрэг домог түүх Эзэн Чингис хаантай холбогддог нь хүн төрөлхтний бүтээсэн сайн муу, сөрөг үр дагавар ихтэй, хэрхэн хүртэж хэрэглэх соёлыг дэлхийн суут хүн журамлан, хуульчлахаас өөр аргагүй өвөрмөц чанартай ундаа билээ.

“Богд Чингис” дууны энэ мэт домог түүх, шүлгийн цэгцэрсэн хэмнэл нь магадгүй тухайн төр ёс, хурим найрыг нээдэг засал домын чанартай дуу байсан байж болзошгүй гэдгийг таамаглал дэвшүүлж болох юм. Учир нь домогт өгүүлэхдээ Чингис хаан “тэнгэрээс хас аягатай бууж ирсэн архийг ганцаар уух гэхэд дөрвөн дүү нь “тэнгэрээс соёрхсон хишиг юунд ганцаар ууна вэ? хуваалцаж ууя” хэмээн гуйхад Чингис тэдэнд өгөв. Тэгтэл дөрвөн дүүгийнх нь аманд нь ороод хоолойд нь эс орсон мөртөө бүр согтжээ. Үүнээс дөрвөн дүү нь Чингис ахаа тэнгэрийн хөвүүн хэмээн нэн бишрэн шүтэж "заяат эзнээс заяагүй бид буруу булаалдав. Эзэн зоогло гэж ахдаа барив” гэж өгүүлдэг. Тиймээс өнөөдөр ч “Богд Чингис” дуу төр ёслол, хурим найрын эхэнд дуулдаг зан заншлын гүн хүндэтгэлтэй, найрын магнай дуу хэвээрээ байсаар байна.

Дүгнэлт

“Богд Чингис” дуу нь монгол туургатны хэмжээнд эзэн богд Чингис хааны нэрээр нэрлэгдсэн, түүний алдрыг мартсан эрт үеэс өнөө цагт хүрч ирсэн цөөн дууны нэг юм.

Шүлэг болон аялгууны хэд хэдэн хувилбартай бөгөөд хөрш зэргэлдээ угсаатны бүлгүүдэд тархан дэлгэрч өвөрмөц соёлыг үүсгэсэн нь бидний бүртгэлээс тодорхой харагдаж байна. Тус дуу хуримын зан үйлийн салшгүй хэсэг болсон нь монголчууд ураг барилдах хуримыг **төрийн хэрэг** гэж үздэгтэй холбоотой байж нэг талаас эзэн богд Чингис хаанаа нэрлэж дурсаж, түүний гаргасан зан журмыг сахин мөрдөхийг сануулсан дуу юм.

Тус дууны шүлгийн агуулга тэнгэрээс Чингис хаанд хас аягатай архи бууж ирж дөрвөн дүүтэйгээ амссан тухай өгүүлдэг аман үлгэр болон “Алтан товч”, Саган сэцний “Эрдэнийн товч” гэсэн түүхэн зохиолтой далд сэмжээр холбоотой мэт санагдана. Эдгээрт Чингис хаан архийг хүртээд согтохгүй байхад дүү нар нь согтуурхсан, тэр цагаас архийг хүндэлж амсдаг болсон, архи уух заншлыг өгүүлдэг билээ.

Мөн дуунд монголчуудын сахиж ирсэн, хойшид ч даган мөрдөх нийт монголчуудын журмыг Чингис хаан зохиосон хэмээн далд утгаар өгүүлжээ. Энэхүү зан журам нь түүхэнд “Чингисийн билиг сургаал” хэмээн үлдсэн нүүдэлчдийн ахуй амьдрал, төр, нийгмийн бүхий л тогтолцоо, гүн ухаан, зан үйл, цээр ёс, эрчлэн дайн тулааны нөхцөлд ч монгол хүн бүрийн эрхэмлэн санаж, сахиж явах Чингис хаан (9 өрлөг)-ны гүн гүнзгий тунгаан өгүүлсэн мөрдлөг юм. Эзэн Чингис хаан зөвхөн дайн байлдаан хийж Ази Европыг эзэлсэн хэрэг биш, харин журам дүрэм, хуулиар их төрөө байгуулж зассан мэргэн эрдэмтэн гэдгийг бид мэддэг. Тиймээс “Чингис хааны билиг сургаал” -ыг ард иргэд журам болгон мөрдөж байнаас үүдэн “Их засаг” зэрэг олон хууль тогтсон билээ. Тийм түүхэн үйл явдлыг уг дуунд өгүүлсэн учир бичвэрт хийсэн тоон үзүүлэлтээс харж болно.

Утгын гол үгс	Давталтын тоо	Шүлгийн бичвэрт эзлэх хувь
Журам аа	3	6.82
зан журам аа	3	6.82 / 13.64
Зохиосон	3	6.82
монголын зан	3	6.82 / 13.64
монголын зан журам аа	3	6.82 / 20.45
Чингисийн	3	6.82
Чингисийн минь	2	4.55 / 9.09
Чингисийн минь зохиосон	2	4.55 / 13.64

Чингис хааны билиг сургаал” нь “Оюун түлхүүр”, “Монголын нууц товчоо”, “Эрдэнийн товч”, “Алтан товч” болон “Судрын чуулган” зэрэг түүхэн сурвалж ном сударт шингэн үлдсэн бөгөөд Төр засгийг удирдах, эрдэм оюун, бие сэтгэл, ёс суртахууны эрхэмнэл хүндлэл, цэрэг дайн, гүн ухаан, хүмүүжил, эв нэгдэл зэрэг олон талтай. Тухайлбал, Ийм, оюун ухааны чанд мөрдлөгтэй байснаар бүгд нэг зорилготой нэгдмэл байж Монгол хэмээх дэлхийн хамгийн том эзэнт гүрэн оршин тогтнож байжээ. Чухам тиймээс

Биеэ засахуйн ёсонг
Билиг сургаалаас сурмуй
Биеэ засахуйн эрдмийг
Сурах дадахаар олмуй

хэмээн монголчууд тус сургаалыг “хамаг олноороо, бүгдээрээ” чандлан сахиж, төрөө нягт хүрээлэн архи сархдаа сөгнөн дэмжиж байсныг тус дуунд өгүүлжээ.

Ном зүй

А. Монгол хэлээр:

Бөххад, Н., Отгонбаатар, (2005). *Үзэмчин урлагийн чуулган-дээд “Үзэмчин ардын домогт дуу”*, Өвөр Монгол: [Bökhkhad, N., Otgonbaatar, *üzemchin urlagiin chuulgan-deed üzemchin ardiin domogt duu*, Övör Mongol. 2005]

“Монгол домгийн цоморлиг” (2005). Эмхэтгэсэн Х.Сампилдэндэв, Улаанбаатар: [Mongol domgiin tsomorlig. Emkhetgesen Kh.Sampilden-dev. Ulaanbaatar: 2005]

Гаадамба, Ш. (1989). *Утга зохиолын онолын үндэс*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн хороо. [Gaadamba, Sh. *Utga zokhioliin onoliin ündes*. Ulaanbaatar: Ulsiin khevleliin khoroo. 1989]

Галбаяр, Г. (2017). *Монгол шүлэг дэх задгай буюу чөлөөт хэмжээт шүлгийн зүй тогтол*. Tokyo university of foreign studies, Area and culture studies -95 [Galbayar, G. *Mongol shüleg dekh zadgai buyu chölööt khemjeet shülgiiin züi togtol*. Tokyo. 2017]

Дорж, Д., & Улаангэрэл, Д. (2011). *Тэнгэр газрын хүн аялгуу*, Өвөр Монгол: [Dorj, D., Ulaangerel, D. *Tenger gazriin khün ayalguu*, Övör Mongol. 2011]

Ласагмаа. (2004) *Задгай шүлгийн тухай судлал*, ӨМСХХ: [Lagsagmaa. *Zadgai shülgiiin tukhai sudlal*. ÖMSKHKH. 2004]

Цэрэнсодном, Д. (1977). *Монгол шүлгийн онол, түүхийн зарим асуудал*, (Тэргүүн дэвтэр) Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Tserensodnom, D. *Mongol shülgiiin onol, tüükhiiin zarim asuudal*. Ulaanbaatar: Ulsiin khevleliin gazar. 1977]

Б. Гадаад хэлээр:

Attridge Derek, (2013). *Moving words. Eorms of English poetry*. Oxford University Press:

Wainwright, J. (2004). *Poetry: The Basics*. XVI, 223 p.

Круглов, Ю.Г. (1989). *Русские обрядовые песни*. Москва:



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.